



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/82

Сангийндалай

Малчдад сургалт зөвлөгөөн зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5, 59.1.8 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал аж ахуйн салбарт төрөөс баримталж буй бодлого чиглэлийг танилцуулах, тус салбарт тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх, малын ашиг шим үүлдэр угсааг сайжруулах бэлчээрийг зохистой ашиглах, сайн туршлага судлуулах зорилгоор Малчдын сургалт зөвлөгөөн-2023 арга хэмжээг зохион байгуулсугай.

2. Тус арга хэмжээг зохион байгуулах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Малчдын сургалт зөвлөгөөнийг зохион байгуулах ажлын хэсгийн дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Г.Энхдэлгэр (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Д.Цогбадрах (1-р багийн Засаг дарга)

Н.Гансүх (2-р багийн Засаг дарга)

Д.Баянмөнх (3-р багийн Засаг дарга)

Д.Мөнхбаатар (4-р багийн Засаг дарга)

Д.Ууганбаяр (5-р багийн Засаг дарга)

Ж.Өлзийжаргал (6-р багийн Засаг дарга)

И.Дүрзээ (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Б.Нандинцэцэг (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (О.Базаррагчаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ЛХАГВАМАНДАЛ

